

## ТҮҮХ, СОЁЛ

## Э. Пунцаг

**МОНГОЛ-ЭНЭТХЭГИЙН СОЁЛЫН ХАРИЛЦАА  
ЭРТ ЭДҮҮГЭЭД**

Монгол, энэтхэгчүүд чухам хэзээ хэрхэн бие биеэ мэдэх болсон, тэдгээрийн хоорондох соёл, иргэншлийн харилцан холбогдол, харилцааны тухай асуудал манай эрдэмтдийн сонирхлыг эртнээс татсаар иржээ. Харин энэ асуудлын түүхт үндэс төлөв байдлыг тусгайлан судалж туурвисан эрдэм шинжилгээний бүтээл төдий л элбэггүй байна. Гэхдээ БНМАУ-ын Шижнлэх Ухааны Академи, түүний харьяа нийгмийн ухааны хүрээлэнгүүд Энэтхэг, Монголын соёлын хэлхээ холбоогоор хэсэгчилсэн судалгаа хийж энэтхэгийн зарим эрдэмтэд, тэдний бүтээлээр нилээд тооны ном, өгүүлэл хэвлэн нийтлэх болсон нь сайшаалтай бөгөөд Монгол дахь дорнодахины судлал, түүний дотор энэтхэг судлалын талаар сүүлийн үед олсон амжилт гэж үзүүштэй.

Өөрийн өвөрмөц соёлтой нүүдэлчин монгол аймгууд нь эрт дээр үеэс эхлэн хол ойрын улс аймгуудтай соёлын хэлхээ холбоотой явж иржээ. Тийм орны нэг бол Энэтхэг юм. Монголын түүхчид Монгол, Энэтхэгчүүдийн хэлхээ холбоог ихэвчлэн Монголд буддийн шашин дэлгэрсэн үетэй холбож үздэг нь зүйн хэрэг боловч буддийн шашин Монголд төрийн болон үндэсний шашин болж дэлгэрэхээсээ өмнө чухам хэдийд анх нэвтэрч эхэлсэн, бүдда (МЭӨ 567-487)-гаас өмнө буюу одоогоос 2500 гаруй жилээс цааш Монгол, Энэтхэгийн хооронд ямар нэгэн харилцаа байсан эсэх талаар нягтлан судалсан нь ховор атал уг асуудал Ази тив, ялангуяа Төв Азийн нүүдэлчдийн эртний соёл иргэншлийн түүхтэй холбогдох зангилаа асуудлын нэг юм.

Энэтхэгийн түүх бичлэгт одоогоос 5 мянган жилийн тэртээ Инд<sup>1</sup> мөрний сав газарт тогтсон Мохенджо-Даро-Хараппын (археологчид Умард Энэтхэгийн соёлын эртний дурсгалт хотуудыг одоогийн баруун Панджаб ба Пакистанаас олдсон газрын нь нэрээр тийнхүү нэрлэжээ-Зохиогч) соёлыг Газрын дундад тэнгис, Төв Азийн соёл иргэншлийн нөлөөтэй гэж үздэг ажээ.<sup>2</sup> Энэхүү Хараппын соёл одоогийн өмнөд Энэтхэгийн дравид хэлтний өвөг дээдэстэй холбоотой гэж зөвлөлтийн болон бусад орны энэтхэг судлаачид бичиж байна.<sup>3</sup>

Гэтэл дравид ба фин-угор буюу алтай хэлний хооронд холбоо байж болох учрыг XIX зууны үед Р. Калдвелл дэвшүүлж тавьсан байхад Я. Бацек одоогийн дравид, монгол хоёр хэлийг эрт цагт нэг овгийн хэл байсан гэж үзэж байна.<sup>4</sup>

1. Инд мөрнийг энэтхэгчүүд дээр үед Синду гэж байсан бөгөөд XIII зууны үед зохиогдсон «Монголын нууц товчоонд» түүнийг Син мөрөн гэж бараг энэтхэг галигаар нь бичсэн нь сонирхолтой. («Монголын нууц товчоо», УБ., 1947, 257-р талд үзнэ үү.)

2. A L. Basham. The Wonder That Was India A Survey of the Indian Culture of the Sub-Continent before the Coming of the Muslims Bombay, 1963. p. 19—29

3. Культура Древней Индии. М., 1975, с. 9, 171.

4. Олон улсын монголч эрдэмтний III их хурал. УБ. 1977, II боть, 50-р тал

Манай эриний өмнөх 3000 жилийн тэртээ дарвид хэл энэтхэгт дэлгэрсэн ба түүнээс хойш 500-гаад жилийн дараа Хараппын соёл үүссэн цаг үе сүрхий авцалдаж байгаа нь дээрх нотолгоонуудыг улам үндэстэй болгож байна. Энэ үе нь манай орны неолитийн үе (МЭӨ IV—II зуун) юм. Эдгээр баримтад түшиглэн монгол угсааны өвөг дээдсийн төлөөлөгчид Инд мөрний сав газарт МЭӨ II мянган жилийн дунд үеэс үүссэн<sup>5</sup> энэтхэгчүүдийн анхны соёлтой харилцан нөлөөлөлцөж дэлхийн энэ районд Перс, Меспотам, Египитийн иргэншилтэй ойролцоо үед хөгжсөн хүн төрөлхтний ууган иргэншлээс хандив хүртэн, мөн зохих хувь нэмэр оруулжээ гэж үзэж болмоор ажээ.

Энэтхэгийн эрдэмтэн П. С. Чоудури Монгол, Энэтхэгийн анхны түүхэн хэлхээ холбоог манай эрний өмнөх тавдугаар зуун буюу бүр түүнээс ч эрт үед тогтсон гэж үзэж байгаа юм.<sup>6</sup> Энэ нь Энэтхэгт болон Монголд аль хэзээнээ улс гүрэн буй болсон үе бөгөөд тухайлбал одоогийн монгол нутагт МЭӨ XII зууны үед тогтсон<sup>7</sup> хүннү улсын мандах үетэй ойролцоо болно.

Монгол, энэтхэгчүүдийн хооронд ийнхүү түүхийн өмнөх эрт дээр үеэс үүсч хөгжсөн хэлхээ холбооны нэг бол соёлын харилцаа юм. Академич Ш. Бира бүр манай эриний өмнөх нэгдүгээр мянган жилийн сүүлчээр Ази тивийн гүнээс нүүдэлчин аймгууд нүүж Умард Энэтхэгт хүрсэн тухай, тэрхүү нүүдэл суудлын их хөдөлгөөний дүнд «нийгэм улс төрийн болон угсаатан ба соёлын зүйл бүрийн уламжлал хоорондоо холилдон хутгалдах гүн гүнзгий түүхэн үйл явц үүсэн гарсан» тухай бичсэн билээ.<sup>8</sup>

Энэхүү Төв Азийн нүүдэлчин аймгийн нүүдэл суудлын их хөдөлгөөн, түүний дүнд үүссэн холилдомол соёл бий болох үйл явцад Төв Азийн гол нүүдэлчин аймаг монголчууд өртөгдөөгүй, уг үйл явц тэднийг тойрон гарсан гэж үзэх үндэсгүй юм.

Профессор Э. Шмидтийн бичсэнээр цус холилдсон монгол-энэтхэг холимог аймгууд Гималайн нурууны өмнө бэл Дардистанаас зүүн тийш байжээ.<sup>9</sup> Мөн ийм нотологоог профессор П.П. Каран нарын эрдэмтэд хуваалцаж өөрсдийнхөө номд бичихдээ: «Төвдөөс монгол арьстан аймгууд, Умар Энэтхэгээс индо-аричууд, Ассам, Дээд Бирмээс Лепча нар ирж Гималайн хөндийд нутаглан суурьшиж тусгай маягийн соёлыг хөгжүүлэв гэжээ.<sup>10</sup> Эдгээр нь одоогийн Сикким, Бутан хавийн район бөгөөд тэнд тухайн үедээ энэтхэг-монголчуудын өвөг дээдсийн өвөрмөц холимог соёл тогтож байжээ.

Гарал үүсэлтэй нь холбож Бутаны монгол хүн ам гэж бичих явдал Энэтхэгийн тухай ном зохиолд одоо ч үзэгдэнэ. Эдгээр нь Монгол Энэтхэгүүдийн өвөг дээдэс эрт дээр үеэс шууд буюу тойруу замаар уулзан хутгалдсанаас эхэлсэн соёл иргэншлийн холын холбоотойг гэрчилнэ. Чулуун зэвсгээс эхлэн феодалын байгууллын үеийг хүртэлх өөр өөр цагийн эртний судлалын дурсгалууд манай орноос маш баялаг олддогийн учрыг

5. Всемирная история. М., 1955, т. 1, с. 230; A. L. Basham, op. cit., pp. 10-30

6. P. C. Choudhury. The Mongols and India: Their Past Relations (Lecture delivered at the Institute of Philosophy, Sociology and Law), Ulan-Bator, 1976.

7. МЭӨ XII—VIII зууны үеийн хятадын Чжоу улстай мөр зэргэцэн оршиж байсан Хүннү нарын улсыг Э. Шмидт одоогийн монгол нутагт МЭӨ 1200 оноос цааш байгуулагдсан гэжээ. («История Человечества» II, СПб, 1905 (2) с. 129) (Хүннү нарын тухай хятадын түүх сурвалжид манай эриний өмнөх XV зууны үеэс эхлэн тэмдэглэсэн гэдэг-зохиогч).

8. Ш. Бира. Монгол ба Төв Азийн орнууд. БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн мэдээ. 1976. № 6, 29-р тал.

9. Э. Шмидт, Индия-«История Человечества», II с. 346

10. Pradyumna P. Karan, William M. Jenkins. „The Himalayan Kingdoms Bhutan, Sikkim and Nepal New York, 1963. p. 14.

эрдэмтэд Монгол орон нь өрнө дорно зүгийн соёлын чухал төвүүдийг эрт цагаас эхлэн холбож ирсэн түүх-газар зүйн нөхцлөөр тайлбарласан явдал ч байдаг.

XX зууны эхэн үеийн археологийн шинжлэх ухааны томоохон амжилт болсон Ноён уулын дурсгалыг 1924—1926 онд нээснээс хойш Ноён уулын соёл гэдэг нэрийн дор Хүннү нарын соёлыг хүчтэй судлах болж Хүннү гүрэн ялангуяа Модун Шаньюй (МЭӨ 204—174)-гийн үед хятадын хан улс, хуучин Грек-Бактрийн улсын нутагт тогтож байсан Кушаны эзэнт гүрэнтэй мөр зэрэгцэн байсан томоохон улс бөгөөд Евроазийн олон ард түмний түүх соёлын явцад гүнзгий ул мөр үлдээсэн тухай д-р Н. Сэр-оджав цохон дурджээ<sup>11</sup>, Манай эриний өмнөх мянгаад жилээс хойш манай эриний VI зууны хоорондох Энэтхэгийн уламжлалт утга зохиол, ном сударт Хүннү нарын талаар олон баримт байдгийн дотор хүннү бичгийн тухай дурдсан ажээ.<sup>12</sup> Монгол эрдэмтэд Хүннү нар наад зах нь МЭӨ II зууны үед бичигтэй байсан гэж үзэж байгаа ба өнөө хэр археологийн судалгааны үрээр хүннү бичгийн 50 гаруй тамга үсгийг олж тодруулжээ<sup>13</sup> Харин хүннү бичгийн уг гарал нь цаашдын судалгааны асуудал бөгөөд учир нь зарим эрдэмтэд хүннү бичгийн уг гарлыг брахми бичиг байж таарна гэх бөгөөд зарим эрдэмтэд хүннү нарын бичиг Орхон (Рун) үсгээс үндэслэсэн гэдэг санал дэвшүүлжээ. Хүннү бичгийн 55 үсгийн 23 буюу гуравны хоёр нь Брахми цагаан толгойн 36 үсэгтэй адил төстэй байгаа нь сонирхолтой ажээ. Брахми бичиг нь бүр эртний Энэтхэгийн нигүүлсэнгүй номын хаан гэгч Ашокаас (МЭӨ 273—226) өмнөх үед зохиогдсон бөгөөд хүннү нарын хуучин нутгийн нэгэн болох «Дорнод Түрэгстан» -д МЭ XIII зуун хүртэл хэрэглэгдэж байсан төлөвтэй ажээ.<sup>14</sup> Тийнхүү брахми бичиг хэлбэрийн хувьд адил төстэй болон он цаг, тархсан нутаг районы цар хүрээ зэрэг нь хүннү бичгийн уг гарлыг тогтооход чухал шижим болно. Нөгөө талаар хүннү үсэг Орхон (Рун) бичигтэй маш төстэй байгаа нь хүннү бичиг брахми бичгийн нөлөөний дор Арамайк бичгээс гаралтай гэдэг санал үндэстэй болохыг харуулж байна.

Монгол, Энэтхэгчүүд бүддийн шашин үүсэхээс бүр өмнө соёлын хэлхээ холбоотой байсны өөр нэгэн шинж тэмдэг бол МЭӨ 1500-1000 оны үед хамаарах эртний Энэтхэгийн вед (ухааны) шастирт гардаг шүлэг дуулал нь монголчуудын галын тахилга, тэнгэр, одны тахилга, уул усны сан магтаалтай төсөөтэй, мөн МЭӨ 1000—600 оны үед багтах туульс, тухайлбал Рамаяна Монголд нэвтэрч монгол аман зохиолд шингэсэн зэрэг болно.<sup>15</sup> Сүмбүр уул, галбарвасан гэх мэт өдий төдий энэтхэг нэр үг монгол ардын ерөөл магтаалд орсон нь вед ухааны шастир, туульсын таних тэмдэг болон үлдсэн байж болох юм.

Энэтхэгийн урлаг, утга зохиол, анагаах ухаан болон одон орны судлал Монголд нөлөөлж байсан нь мэдээж бөгөөд Энэтхэгийн ардын аман зохиол бурханы цадиг, цоморлог хэлбэрээр Монголд нэвтэрч улмаар олон зуун жилийн явцад монгол ахуй байдалд нийцэж хувиран хувирсаар академич Ц.Дамдинсүрэнгийн бичсэнчлэн энэтхэг хэлнээс орчуулсан энэтхэг

11. Н. Сэр-оджав, Монголын эртний түүх. (Археологийн найруулал). УБ., 1977, 93—94-р тал.

12. Рагу Вира. Монголын агуу их утга зохиолыг дэлхий дахинд танилцуулая. --- «Олон улсын монголч эрдэмтний анхдугаар их хурал», УБ., 1961, 39-р тал.

13. А. Дамдинсүрэн. Археологийн судалгаагаар нээсэн Хүннүгийн бичиг дурсгал «Монголын эртний түүх соёлын асуудалд» УБ., 1972.

14. Artur Wally, Secret History of the Mongols and other pieces., L., 1963. p. 37.

15. Монголын уран зохиолын тойм. II, УБ., 1977, 263, 372-р тал.

зохиол гэж үзэж эс болох төдийгүй, улмаар монголын ард түмний уран бүтээл болтлоо өөрчлөгджээ<sup>16</sup>.

Хөрш зэргэлдээ Хятадад МЭӨ VI—V зууны үед дэлгэрсэн күнзийн ёс, бомбын суртал (даосизм) Монголд дэлгэрээгүйн шалтгааныг Монголд эртний Энэтхэгийн шашин-улс төрийн үзэл, соёлын нөлөө хүчтэй байсантай холбон үзэх нь зүйтэй юм.

Энэтхэгт 2500 жилийн өмнө үүссэн бүддийн шашин МЭӨ IV—III зууны Хүннү нарын цагт Хотон, Турфан, Куча болон тэр үед хүннү нарын удам угсаа нутаглаж байсан Дорнод Түрэгстаны баян бүрдүүд, хотууд зэрэг Төв Азийн гол замаар дамжин монгол нутагт хүрчээ. «Кушаны нийслэлээс монгол нутагт байнга ирж очилцон буддийн сургаал, бүддийн соёл хятад, монголд нэвтэрсэн байх ёстой»<sup>17</sup> гэж Джавхарлал Неру бичжээ. Бас Кушанчууд нь монголчууд байсан буюу эсвэл монголчуудтай холбооны улс болж байсан гэж мөн номд тэмдэглэсэн байдаг. Кушаны Канишка (78—144)<sup>18</sup> хааны нэр Монголд их алдаршсан байв. XIII зууны 2-р хагаст зохиогдсон монгол дурсгал бичиг «Цагаан түүх»-д «Кушаны монгол» (Kusan-u mongol) гэж тэмдэглэсэн байдаг нь монголчууд Кушаныг монгол угсаатан гэж үзэж байсныг гэрчилнэ.<sup>19</sup>

Бүх Дундад Ази, Афганистан, Энэтхэгийн умар хэсгийг хамран тогтсон Кушан гүрэн нь хөрш зэргэлдээ Хүннүтэй өргөн харилцаатай байсан нь лавтай. Тийм харилцааны урьдчилсан нөхцөл нь ч аль хэзээнээс тавигдсан байжээ. Бүр МЭӨ IV—III зууны үед бүдлийн утга зохиолыг нэвтрүүлэх, тэдгээрийг бусад хэлнээ хөрвүүлэхэд гол үүрэг гүйцэтгэгчид нь их төлөв Төв Азийн орнуудын согд, уйгарууд байсан ба энэтхэгийн шашин номлогчид ч энэ үеэс эхлэн хүннүгийн нутагт хүрэлцэн ирсэн тухай түүх, соёлын дурсгалд үлдсэн баримт байдаг ажээ. Энэ үе нь Энэтхэгт Ашока хаан сууж байсан үе (МЭӨ 268-227) бөгөөд Ашока нь буддизмийг дэлхий дахины шашин болгох зорилгоор бололцоотой бүхнийг хийсэн хүн ажээ.

Тоба-Вэй вант улсын үеийн агуйн зурагт дүрслэгдэн үлдсэн майдар бурханы хүрэл баримал нь МЭ I—III зууны үед Кушаны эзэнт улсад хөгжиж байсан Энэтхэгийн бүддийн урлагийн нэг салбар Гандхара (газар нутгийн нэр) урлагийн галбир төрх ажээ. Энэтхэгийн шашин номногчид Тоба-Вэй вант улсын хаан Тоба хун (471—499)-нд бараалхахаар нийслэл Пинченд айлчлан ирж байсныг зарим сурвалжид тэмдэглэжээ<sup>20</sup>. Түүнчлэн Жужан, Түрэгийн үед, тухайлбал 581—605 оны үед Нариндраяша тэргүүтэй шашин номногч олон энэтхэгчүүд Монголд ирж байсныг гэвш Иштавхай «Дээдэс багш нарын сүмбүмийн гарчиг» гэдэг зохиолдоо дурджээ. Хятад сурвалж зохиолуудаас үзвэл феодалын түрүү үеийн Жужан улс (МЭ IV—VI зуун) Энэтхэгийн Ираай гэгч ламыг «улсын багшаар» залж бүддийн шашинд орсон учир Жужаны хаан 511 оны үед Бүддагийн сувдаар урласан хөргийг хөрш Тоба-Вэй улсад бэлэг болгон барьжээ<sup>21</sup>. Гэтэл мөн үед Өмнөд Монгол, Умард Хятадад ноёлж байсан монгол угсааны Тоба-Вэй вант улс нь Ся Вэнь-ди (471—499) хааны үед 6478 сүм хийдтэй, 77258 лам нартай байсан бөгөөд сүүл хирдээ сүм хийд нь 13000

16. Мөн зохиолын 349-350-р тал.

17. Дж. Неру, Взгляд на Всемирную историю. М., 1975, т. I, с. 140

18. Канишкин амьдран суусан он сарыг олонхи эрдэмтэд ийнхүү үзэж байгаа ажээ

19. Ш. Бира. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд. УБ., 1977, 74, 208-р тал

20. Г. Сүхбаатар. «Сяньби» УБ., 1971, 140—141-р тал

21. Ц. Хандсүрэн, Жужаны аж байдал, соёл, зан заншлын тухай, «Түүхийн судлал» Т. VII, УБ., 1969, 77-р тал.

лам нар нь нэг сая орчимд хүрчээ.<sup>22</sup> Алс холын Монгол оронд буддизм энэ мэт дэлгэрч байсан бөгөөд ялангуяа МЭ V—VII зууны үед Монгол, Энэтхэг улсууд маш өргөн харилцаатай болж, Монгол нь ямар нэгэн хэмжээгээр Энэтхэгийн буддизмийн оюун санааны нөлөөнд оршиж байсныг харуулж байна. Үүнээс үзэхэд Монгол дахь буддизм нь зарим талаар буддист урлаг соёлыг хятад болон түүний чанад дахь улс оронд цаашид түгэн дэлгэрэх хэв загвар зам гүүр болж байжээ

Монголчууд XIII зууны үед буддизмийн махаяна хэлбэрийн «сажаа» хэмээх Төвд салбарыг, XVI зууны үед шарын шашныг төрийн шашин болгон авснаас хойш бүддийн шашин бүхэлдээ улам шуурхай дэлгэрэх болжээ. 1579 онд Түмэдийн Алтан хаан өөрийгөө номын хүрдийг орчуулагч буюу «Чакраварын (Чакраварти) хувилгаан», «номын хаан»<sup>23</sup> гэж өргөм жилжээ. Ийм цол Чингис, Хубилай, Лигдэн хаадад бас байжээ. Энэ мэтээр монголын түүх, түүх бичлэгт монгол хаадын түүх, шашин, төрийг хөрш их гүрэн Хятадтай биш, харин Энэтхэг, Төвдийн хаадын түүх, шашинтай холбох заншил тогтжээ. Ийм хандлага нь дундад зууны үеийн Европын «Эзэнт төрийн шилжих» (translatio imperii) түүх-улс төрийн онолтой төстэй «Дээд төрийн шилжих» гэгч онолын нөлөөгөөр улам ч дэлгэрч анх Пагва (1235—1280) лам боловсруулж, Хубилай (1285—1294) хааны үед 1278—1280 оны орчим зохиогдсон бичгийн дурсгал «Цагаан түүх»-д бүрэн тусгалаа олсон «ертөнц ба номын хоёр ёсон»-*qoуaг yosun (lugs gnis)* буюу төр шашныг хослон барих онол ёсоор тэрхүү бүддийн шашинт төр нь номын хаан захирдаг энэтхэг, төвд, монгол гуравт ээлжлэн тогтох ёстой ажээ. Энэ онолыг нэвтрүүлснээрээ Пагва лам тэр үеийн монголын нийгмийн ноёлогч ангийн эрх ашгийн тулд үйлчилж байсан нь мэдээж юм. Тухайлбал, уг онолын ёсоор монголчуудын төр шашны тэргүүн нар нь «Замбутивийн эзэн хааны» дээр дурдсан «Чакравартина» цол, бас монгол хаад нь эртний Энэтхэгийн «Махасаммата» чимэг зэргийг хэрэглэх эрхтэй байжээ. Ийм хандлага Монгол дахь бүддийн сургаалын бүхий л түүхийн туршид оршиж эцсийн бүлэгт Монгол орон бүддийн соёлд бүрмөсөн шилжих ул үндсийг бүрэлдүүлжээ.

Буддизм Монголд МЭ IV—V зуунд дэлгэрсэн гэдэг боловч чухам нэвтэрч эхэлсэн нь барагцаалбал Хүннү улсын түрүү үе буюу МЭӨ IV—III зууны үе бөгөөд Хятадад Зүүн Хан улс (МЭ 58—75)-ын үед, Төвдөд МЭ VII зууны үед тус тус нэвтэрчээ. Ийнхүү буддизм Монголд эрт дээр үеэс дэлгэрсэн нь санамсаргүй тохиолдол биш бөгөөд Монголын тухайн нийгмийн нэгдмэл улс байх шаардлагаас үүссэн түүхэн үзэгдэл байсны зэрэгцээгээр монголчууд хэзээнээс нааш Хятадаас төр шашин тусгаар, биеэ даасан өвөрмөц соёлтой байхыг эрмэлзэж ирснийг харуулж байна. Юан гүрний үед Хубилай хаан күнзийн суртлаас бүддийн суртлыг чухалчилсан бодлогын талаар Ш. Бира бичихдээ Хубилай нь бүддийн шашныг засаг төрөө бэхжүүлэх улмаар хятад дахь соёл-улс төрийн урсгалын дайралтыг ямар нэгэн хэмжээгээр эсэрүүцэх үзэл суртлын хүчит зэвсэг гэж үзсэн<sup>24</sup> ба энэтхэг-төвдийн соёлын ертөнцөд Монгол орны татагдан орох үйл явц нь Монголд шарын шашин дэлгэрч Манж нар Монголыг ноёрхон эхэлсэн XVI зуунаас хойших үед ч тасалдаагүйгээр үл барам, харин бүр ч хүчтэй болж, улмаар Монголын нийгмийн амьдралын оюун ухааны мандалд хятадын нөлөө нэвтрэх явдлыг сарниулан үгүйсгэх хүчин зүйл бол-

22. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть, УБ., 1966, 105-р тал.

23. Ж. Самбуу. Шашин ба лам нарын асуудалд. УБ., 1961, 28-р тал

24. Ш. Бира. Концепция верховной власти в историко политической традиции Монголов. — «БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд» УБ., 1977, 200-р тал.

сон гэжээ<sup>25</sup>. Энэтхэг шашин номногч нарыг умард ба баруун умардад хүргэсэн зам нь Кашмир, Хотонгийн гол чиглэлээр дайрч байсан хийгээд Дорно-өрнийн худалдааны харилцаанд алдарт «Торгон зам» чухал үүрэг гүйцэтгэсэн шиг Хотонгийн «цаасан зам» нь Умард-Өмнөдийн соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэжээ.

Кашмираас гарч МЭ 381 онд Хятадад очиж олон тооны ном судар орчуулсан кашмир эрдэмтэн Сангабуд, V зууны эхээр Төв Ази, Хятадад ирсэн Бунъятрата, Дармачасас (кашмир эрдэмтэд), энэтхэг лам Дармак шима нарын зэрэг шашин номногч нар монгол нутгаар дайрч явсан нь лавтай бөгөөд VI зууны үед энэтхэг лам Дармагупта нь куча, Харшаар зэрэг нутагт тусбүр хоёр жил сууж ажилласан бололтой мэдээ бий.

Хятадын Тан улс (618—907)-ын жуулчин Тансан лам буюу Сюань Цзэл Буддагийн дүрийг анх үзэж бишрэн гайхаж байсан Турфаны хөндийн хадны бүдда болон Бодисатва (бодисад) гийн гоёмсог бурхан<sup>26</sup>, монголын VII зууны үеийн түүхэнд холбогдох Бугатын чулуун хөшөөнд бүддийн хуврагуудын талаар дурдсан согд бичээс<sup>27</sup> сэлт нь цөм буддизм Төв Азийн дээр дурдсан үүд хаалгаар дамжин баруун ба умард монголд дэлгэрснийг нотолж байна.

Энэхүү түүхэн дээр үеэс эхлэн монголчууд нь Энэтхэг болон Төв Азийн орнуудтай харилцаа холбоогоо хөгжүүлж тэдгээр соёлт орнуудын эерүү нөлөөг соёлдоо шингээн авч байжээ.

Хубилай хааны үед түүний зарлигаар «дөрвөлжин үсэг» хэмээх шинэ бичиг зохиолгосон нь төвд, энэтхэг бичиг дээр үндэслэсэн байх бөгөөд төвд бичиг нь хоёр төрлийн Ашока бичгийн нэг болох харости бичгийн хувилбараас авсан ажээ. 1686 онд Монгол дахь шарын шашны анхны тэргүүн богд Лувсандамбийжалцан (Өндөр гэгээн Занабазар (1635—1723) «соёмбо» хэмээх шинэ үсгийн цагаан толгойг утга үсэг хэмээх бэлэг дэмбэрэлийг эрхэмлэх тэмдэг дүрсээр туурвижээ. Занабазар нь эртний Энэтхэгийн эрдэмтэн Банины МЭӨ IV зууны сүүлчээр зохиосон «Аштадхьяи» буюу «найман бүлэгт» (Astadhyayi) гэгч самгарди (samskrita) «сайтар нийлүүлсэн» хэлний зүйн нөлөөний дор санскрит, төвд үсгийг нарийн зөв галиглах олон тооны тэмдгийг цагаан толгойдоо оруулсан нь илэрхий. Эдгээр нь Монголын соёл хэзээ ч үгүйсгэх гадуурхах соёл байгаагүй, харин өөр бусдаас сурах судлах соёл байсны<sup>28</sup> гэрч юм.

Энэтхэгийн соёл, утга зохиол тухайлбал «Рамааяна»-ын нөлөө тусгал нь монголчуудын эртний утга зохиолоор хязгаарлагдахгүй тэдний оюун сэтгэлд хүртэл нөлөөлж байсныг академич Ц.Дамдинсүрэн монголын лам нарын дотор, сан жасын газарт сармагчны дүрс хөргийг шүтэх явдал элбэг үзэгддэгээр тайлбарлажээ. Тэрчлэн академич Ш. Бира Банин аршийн үндэслэсэн эртний энэтхэгийн Вьякирана буюу хэлний зүйн сургууль Монголд сүүлийн үе хүртэл их алдаршиж монголын хуучин бичгийн хэлний үндсэн дүрмүүд нь Банины сургуулиас шууд ба дам үүсэлтэй онолын гарчгуудын дагуу боловсруулагдсан<sup>30</sup> гэжээ. Мөн зохиогчийн дүгнэснээр

25. Ш. Бира. Монгол ба Төв Азийн орнууд (Монгол ба Төв Азийн бусад орнуудын соёлын харилцааны түүхийг судлахын учир) -«Шинжлэх Ухааны Академийн мэдээ. № 4. 1976, 31-р тал.

26. Дж. Неру. Взгляд на Всемирную историю. М., 1975, с. 195 (Энд бас БНХУА-ын Ганьсу муж, СУАР-ны нутагт орших «түмэн» ба мянган бүддийн (бурханы) агуй»-г дурдаж болно-зохиогч),

27. Ц. Дамдинсүрэн, «Рамааяна Монголд дэлгэрсэн нь» УБ, 1976, 71-р тал. 28. Ш. Бира. Монголын соёлын түүхийг судлах асуудалд«Олон улсын монголч эрдэмтний II их хурал», Боть I, УБ., 1973, 70-р тал.

29. Ц. Дамдинсүрэн, «Рамааяна Монголд дэлгэрсэн нь» УБ., 1976, 9-р тал.

30. Ш.Бира, Монгол ба Төв Азийн орнууд-Шинжлэх Ухааны Академийн мэдээ № 4. 1976, 31-р тал

энэтхэг-төвдийн буддийн утга зохиолын хүчтэй нөлөөний дор монголын төвд хэлний утга зохиол үүсч бүрэлдсэн ба Монголд бүдийн өвөрмөц соёл бий болсон тухай<sup>31</sup> зэрэг олон баримтыг иш татаж болно. Эдгээр баримт нь монгол-Энэтхэгийн соёлын эртний харилцаа, буддийн соёлын нөлөө гэдэг ойлголтын хүрээг улам тэлж Монгол Энэтхэг хоёр нь эрт ба дундад зууны турш соёлын гүн зузаан холбоот хөршүүд байжээ гэж үзэх үндэстэйг харуулж байна.

Монголын соёлд үзүүлсэн буддизмийн нөлөөний талаар ярихдаа түүний шашин бурханы холбогдлын зэрэгцээгээр эртний Энэтхэгийн иргэний соёлын зүйлс Монголд шашинтай хутгалдан нэвтэрч байсныг анхаарах нь зүйтэй юм. Буддизм нь Монголд «Махаяна» (их хөлгөн) суртлын хэлбэрээр дэлгэрэн хэрэглэгдэхдээ монголын төр шашны төрөл бүрийн ёсны хүрээнд энэтхэгийн эрдэм мэдлэгийн өргөн цар хүрээ бүхий санскрит судлалтай хослон явагджээ. Энэ явцын дүнд олон тооны санскрит үг монгол хэлэнд орж иржээ. Жишээ нь:

**санс.**

сүмерү  
двипа  
Ратна  
Кадали  
Сукра  
Брхаспади  
граха  
Чатранга

**МОНГ.**

сүмбэр (Гималай)  
тив (их газар)  
эрдэнэ (үнэт зүйл)  
гадали (жимс)  
сугар (гариг)  
Бархасбадь (гариг)  
гариг (од гариг)  
шатар (тоглоом)

Монгол хэлэнд орсон бурхан, шашин, судар, мутар, шүлэг, бадаг зэрэг үгүүдийг цөм согд, уйгараар дамжуулан санскрит хэлнээс авчээ. Энэтхэг зээлдмэл үгнүүдээр хэрэв толь хийвэл латинаас орос хэлэнд орсон үгийн хэмжээний толь болох тухай манай эрдэмтэд тэмдэглэжээ. Буддизм нь ийнхүү Монголд тэр үеийн Азийн бусад орнуудын нэг адил чухамдаа дан ганц шашин ч биш, харин шинэ философи, урлаг соёл, уран зохиол мэтээр нэвтэрч монголчуудын оюуны соёлын хөгжилтөд шинэ үзэгдэл болжээ.

Монголд анх буддизм дэлгэрсэн үнэн байдал энэ мэт агаад уг байдал нь буддизмийг Хятадын Мин, Чин улсаас Төв Азийн нүүдэлчид түүний дотор ялангуяа монголчуудыг хооронд нь дайсагнуулах, тэдний «дайнч омгийг» дарж устгах зальхай бодлогодоо ашиглаж эхлэх хүртэл харьцангуй богино хугацаанд үргэлжилсэн боловч буддийн соёлын ерөнхий нөлөө нь буурсангүй харин ч байнга өсөн нэмэгдсээр байжээ. Монгол эрдэмтэд бичиг зохиолдоо Ганжур (зарлигийн орчуулга)-т орсон Нагаржунын<sup>32</sup> «Махаяна» философийн судар, Данжур (шастирын орчуулга)-т орсон мадьямика хэмээх дундад үзлийн шастир сэлтээс иш татсан нь олонтой байдаг ажээ. Тэд философийн хялбарчилсан нэр томъёо хүртэл зохиож байжээ. Жишээ нь Пражнапарамита (билгийн чанад хязгаарт хүрэх)-ыг монгол санскрит үг хослуулан Билиг Барамид гэжээ.<sup>33</sup>

Буддист утга зохиол, түүний дотор онол практик, яруу найраг орчуулах ажил бүр Тоба улсын (IV—VI зуун) үеэс хөгжжээ. Тоба улсын хаа-

31. Роль кочевых народов в цивилизации Центральной Азии. УБ., 1974. сс. 63 66,.

32 Нагаржуна (Гомболүдүв) нь Маджамика («Дундат») суртлын гол сэдэв мадьямика карика-г зохиосон эртний Энэтхэгийн нэрт философичдийн нэг болой.

33. Проф. ш. Лувсанвандан, Маднамика буюу дундад үзэл. (Буддийн судлалын олон улсын их хуралд зориулсан илтгэл, Нью Дели Энэтхэг, 1977).

ны ордонд энэтхэгийн шашин номногч хоёр лам шавилан сууж бүддийн ном судар орчуулж<sup>34</sup> байсан ба ийм ажлаар VII зууны үед анхдугаар Жавзандамба хутагт богд Лувсандамбийжалцан өндөр гэгээний (1635—1723) үед «Чулуун хуруут»-ын зэрэг энэтхэгийн хоёр азар (багш професоор-санс. «ачария») сууж байжээ.<sup>35</sup> МЭӨ 200-гаад оны үед Кашмирт зохиогдсон гэдэг Панчатантра («Таван шастир») хэмээх алдарт үлгэр анх VI зууны үед перс хэлэнд орчуулагдаж XIII зууны үед Персийн эрдэмтэн Ифтихар Эддин Мохаммед перс хэлнээс монголчилжээ.<sup>36</sup>

XVIII зууны болон XX зууны эхэн үед монголын шашны сургуулиудад бүддийн сургаал гурван савын номын зэрэгцээгээр эртний Энэтхэгийн их таван ухаан, бага таван ухаан гэдгийг эрэмбэ дараалан заадаг байжээ. Их таван ухааны нэгэнд нь анагаах ухаан ордог ба монголчуудын ардын эмнэлэг нь эртний Энэтхэгийн хүн эмнэлгийн «насны шастир» буюу Аюурвед системтэй уялдаатай ажээ. Ялангуяа энэтхэгийн утга зохиолын орчуулга нь монголын соёлын хөгжилтөд багагүй нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй. Монголын утга зохиолчид эртний Энэтхэгийн яруу найраг Боди чаръяаватараг XIV зууны үед орчуулсан бол хятадын «Гурван улсын түүх», «Хүйтэн уулын бичиг» зэрэг үргэлжилсэн үгийн зохиолыг XVIII XIX зууны үед орчуулжээ. Түүнчлэн Монголд Хятадаас орчуулсан үлгэр нэг зуу гаруй байхад Энэтхэг Төвдөөс орчуулсан нь хэдэн зууд хүрнэ. Хятад нь Баруун Хан улсын үеэс эхлэн 1700 жилийн дотор бүддийн утга зохиолоос нийт 5536 боть 1440 зохиол орчуулсан мэдээ байдаг. Энэ талаар Монголд гүйцэд тоо баримт тодорхойгүй. Гэвч зөвхөн хоёр том цоморлог-монгол Ганжур, Данжур нь 334 боть (Ганжур 108, Данжур 226) 4619 зохиол (Ганжурт 1161, Данжурт 3458) багтаасан нь тодорхой билээ.

Эртний энэтхэгийн иргэний буюу шашингүйн чанартай утга зохиолоос Валмики арш 2500 жилийн тэртээ бичсэн гэж үздэг алдарт туульс «Рамаяна» нь Монголд дэлгэрснийг түүний товч агуулга бүхий зургаан хувилбар олдсон явдал гэрчилж байна.

VII зууны үеийн энэтхэгийн агуу их яруу найрагч бөгөөд онолч Дандины бичсэн «Зохист аялгууны толь» (Кавъядарша), агуу их санскрит яруу найрагч Калидасын «Үүлэн зардас» (Мэгадута) зэрэг зохиолууд нь хэд хэдэн дахин орчуулагдаж тэдгээрийн талаар монголын эртний болоод эдүгээн эрдэмтэд, зохиолчид олон тооны судалгаа зохиол туурвижээ.<sup>37</sup>

XVII—XVIII зууны үеийн монголын эрдэмтэд, зохиолчдын бүтээлд санскрит утга зохиол, ялангуяа XVII зууны үед орчуулсан Банины «их хэл зүй» (Аштадхья), XVIII зууны үед орчуулсан Дандины «Зохист аялгууны толь» зэрэг нь ихээхэн нөлөөлжээ. Энэ суртлыг дагагчдын дотроос Ойрадын Зая бандид Намхайжамц (1599—1662), Халхын Зая бандид Лувсанпэрэнлэй (1642—1715), Цахар гэвш Лувсанчүлтэм (1770—1810) болон бас бусад олон эрдэмтэд өөрийн орны соёлын сан хөмрөгт үнэт дурсгал үлдээжээ. Гэвш Лувсанчүлтэм нь энэтхэгийн бичгийн алдарт дурсгал «Панчатантра», «Рамаяна» хоёрын талаар тайлбар сэлтийг зохиожээ.

34. БНМАУ-ын түүх, боть I, 1966, 118-р тал

35. Монголын уран зохиолын тойм. Iө, УБ., 1977, 345—347-р тал

36. БНМАУ-ын түүх, боть I. 1966, 408-р тал Академич Ш.Бира. Монгол ба Төв Азийн орнууд--ШУА-ийн мэдээ, № 4 1976, 32-р тал. Монголын уран зохиолын тойм II, УБ., 1977. 265-р тал.

37. Ш. Бира. Монгольские комментарии к «Кавьядарше» Дандина. УБ., 1963 Sh. Bira, The Dandin's „Kavyadarsa in Tibet and Mongolia", *Studia Mongolica* tomus V (13) Fasc. 5. Ulan-Bator, 1977.

Б. Ринчен. «Үүлэн зардсан» 1962, «Зохист аялгууны толь» УБ., 1975 зэрэг зохиолуудад тодорхой бий.

Энэтхэгийн нэрт яруу найрагч Шантидэва(VII зуун)-гийн бичсэн гүн ухааны яруу найраг «Бодичаръяаватара» (Бодисад нарын явдалд орох)-г бүр XIV зууны үед орчуулжээ. Энэ зохиолыг анх бандид Чойжи Одсэр 1305 онд бүхлэд нь монголоор орчуулж 1312 онд 300 хуудас тайлбарын хамт нэг мянган хувь хэвлүүлжээ.<sup>38</sup> Зохиолын талаар Ц.Дамдинсүрэн, Э. Хэниш, В. Кливз нар нарийвчлан судалсан байна. Монголын бичгийн хүмүүс ном судрыг зөвхөн орчуулж хөрвүүлэхээр хязгаарласангүй, харин монгол, төвд хэлээр тусгай бүтээлүүд, тайлбар сэлтийг туурвин бүтээж байжээ. XVII—XVIII зууны заагт амьдарч байсан Үзэмчний гүн Гомбожав Монгол Данжур, Төвд Ганжурт орсон хэд хэдэн бүтээл орчуулжээ. Тэрээр бас эртний Энэтхэгийн талаар элбэг материалтай Тан улсын Тансан лам буюу Сюань Цзан (596—664)-ын 646 онд бичиж дуусгасан «Да Тан си-юй-цзи» (Баруун орнуудын тухай Тан улсын тэмдэглэл) гэдэг номыг төвдөөр орчуулжээ. Энэ зохиолын бүрэн бус төвд орчуулгыг Ш. Бира 1974 онд нийтлүүлсэн бөгөөд харин цаашид энэ мэт сурвалж зохиолуудыг монгол хэлээр орчуулан хэвлэж сэхээтний өргөн хүрээний хүртээл болгох нь зүйтэй билээ. Гүн Гомбожав нь төвд, монголоор ном судар орчуулахын зэрэгцээгээр «Дундад улсад бурхан шажин дэлгэрсэн түүх», «Гангын урсгал» (Энэтхэгийн Ганга мөрний нэр-э.п.) гэх мэт томоохон зохиолууд бичжээ<sup>39</sup>

Монгол зохиолчид ингэж ном зохиолоо төвдөөр бичдэг байсан учир монголчуудын төвдөөр бичсэн бүтээлүүд нь энэтхэг-төвдийн буддийн утга зохиолын шууд нөлөө бүхий өвөрмөц чиглэл болжээ. Тийм сурвалж зохиолууд нь хэдэн зуун боть болох бөгөөд ихэнх нь шашны холбогдолтой мөн зарим нь түүх, яруу найраг, анагаах ухаан зэрэг сэдвээр ажээ. Тэдний дотроос нэрд гарсан нь Агвандандар (1758—1830), Агванбалдан (1797—1864), Ишбалжир (1704—1788), буддийн гүн ухаан, логигоор 12 боть бичсэн Ш. Дамдин (1867—1937) нарын зэрэг эрдэмтэд болно. Эдгээр эрдэмтдийн нэг онцлог нь тэд эртний Энэтхэгийн философийн давшилт уламжлалыг баримтлах хандлагатай бөгөөд яруу найрагт бол Дан дины (VI зуун) онолд тулгуурладаг байжээ.

Дүгнэж үзвэл эртний энэтхэгийн ардач үзэлтэй иргэний уран зохиол нь хятадаас түрүүлж монголд нэвтрээд монголчуудын аман зохиолтой ойр дөхөм учир хялбархан монголжиж монголын утга зохиолд бүхэлдээ давшилт үүрэг гүйцэтгэсэн нь үнэнтэй юм.<sup>40</sup> Улаанбаатарын улсын номын сан нь буддийн утга зохиолоор дэлхийд баян гэгдэх номын сангийн нэг бөгөөд энд XI зууны буддийн шашны ариун судар-Астасакхасрика Пражнапарамита<sup>41</sup> хэмээх дал модны навчин дээр бичиж олон тооны өнгөт зургаар чимэглэсэн санскрит гар бичмэл зэрэг ховор нандин ном судар ч бий. Буддийн болон энэтхэг судлалд монгол зохиогчдын оруулсан нэг чухал хувь нэмэр бол монгол төвд эрдэмтдийн дунд ихэд дэлгэрсэн тайлбар зохиолын хэлбэр юм. Зөвхөн Дандины «Зохист аялгууны толь»-иор 10 шахам том тайлбар, хэдэн зуун товч тайлбар жишээ шүлэг бичигджээ. Тийнхүү монгол ба монголчууд нь буддийн утга зохиолыг дан ганц нандигнан хадгалахаар зогсохгүй харин ард түмний соёлын арвин их өвд түшиглэн шинэ ном зохиолыг сэлбэн туурвих замаар буддийн утга зохиолыг арвижуулж байжээ. Буддийн утга зохио-

38. Д. Цэрэнсодном, «Связь монгольских письменных памятников из Турфанской коллекции с литературой других народов Центральной Азии.-«роль кочевых на родов в цивилизации Центральной Азии» УБ. 1974, 383-р талд үзнэ үү.

39. Монголын уран зохиолын тойм П, УБ., 1977, 385-р тал

40. Г. И. Михайлов. Литературное наследство монголов. М. 1969, с. 119-121

41. Монголоор «найман мянгат», төвдөөр «Жадамба»

лын сан хөмрөгийн баялгаар Монгол нь Шри Ланка (Цейлон-зохиогч), Хятад ба Төвдтэй зэрэгцэх юм<sup>42</sup>.

Философи, логик, хэл зүй, яруу найраг, хүн эмнэлэг, урлаг, астрологи зэрэг хүн төрөлхтний мэдлэгийн янз бүрийн салбараар бичсэн эртний энэтхэг, төвд эрдэмтдийн бүтээлүүдээс бүрдсэн Монгол Ганжур, Данжур бол буддийн нэвтэрхий толь бичгийн ховор нандин дурсгал болно. Эдгээрээс үзэхэд Монгол Ганжур, Данжур нь их ба бага таван ухааны номуудыг багтаасан учир энэтхэг ба хятад трипитака (гурван савын ном) аас ялгаатай ажээ. Монгол Ганжур, Данжурт дээр дурдсан Дандины «Зохист аялгууны толь», «Үлгэрийн далай» (санс. Дамамука-намасутра), Калидасын «Үүлэн зардас» (санс. Мэгадута) гэх мэт олон тооны үлгэр тэрчлэн 500 гаруй цадиг<sup>43</sup> оржээ.

Эдгээр их цоморлогийг анх XIV зууны үед төвд эрдэмтэн Будон Ринчиндүв эмхтгэж Лигдэн хааны (1604—1634) зарлигаар монгол эрдэмтэд Ганжурыг 1629 онд орчуулж дуусчээ. Энэ асар их ажлыг Гунгаа-Одсэр тэргүүтэй 70 шахам эрдэмтэн гүйцэтгэж 1720 онд 108 ботиор хэвлэн гаргажээ (Модон бар). Данжурыг 200 орчим орчуулагчид 1742 онд орчуулж дуусгажээ. Энэхүү чухал орчуулгын ажилд зориулж «Мэргэд гарахын орон» нэртэй монгол-төвд нэр томъёоны толь тусгайлан бэлтгэжээ. Хоёр цоморлогт багтсан зарим зохиол нь бүр XIV зууны үед орчуулагдсан бөгөөд тийм зохиолыг зөвхөн дахин хянаж засварлаад нийтэлсэн нь мэдээж.

Гэвч энэ бяцхан өгүүлэлд төвд, энэтхэгээс орчуулсан бүх зохиолыг авч үзэх зорилго тавьсангүй. Харин энэтхэгийн утга зохиолтой холбогдол бүхий гарал үүслийн хувьд иргэний чанартай олон тооны бүтээлээс заримыг дурдах нь зүйтэй билээ. Үүнд «Энэтхэгийн Бигармижид хааны үлгэр» хэмээх 32 бүлэг бүхий зохиол, Ража буюу «Арж Борж хааны намтар» гэж алдаршсан үлгэр, «Кэсэнэ хааны намтар» зэрэг болно. Монгол эрдэмтэд энэ мэт зохиолууд дахь энэтхэгийн нөлөөг үгүйсгэдэггүй боловч тэр зохиолууд нь монголчуудын дунд олон зуун жилийн турш яригдсаар монголчуудын аж байдал, амьдралын хэв маягт зохицуулан монголчлогдож улмаар монгол үндэсний сонгомол зохиол мэт болж хувирсан гэж үздэг юм.

X зууны үед умард Энэтхэгийн вант улс (VII-X зуун)-ыг захирч байсан Ража Божа нь улс төрийн хэрэгт онцын гавьяагүй боловч соёлын хөгжилтөд ихээхэн анхаарч ирсний учир үлгэр домгийн нэг гол баатар болсон тухай Дж. Неру цохон тэмдэглэжээ.<sup>44</sup>

Ража Божа нь хэдийгээр тийнхүү түүхт хувь хүн байсан боловч түүний тухай үлгэрийн монгол хувилбар нь энэтхэг үлгэрийн хэлбэр төрх, нэр усыг ашиглан зохиосон монгол чимэгтэй монголын ард түмний уран бүтээл болжээ. «32 модон хүний үлгэр»<sup>45</sup>, «Шидэт хүүр» гэх мэт үлгэрүүд нь мөн л ийм шинжтэй ажээ.

42. Ш. Бира. К вопросу изучения буддийского литературного наследия монголов. «Роль кочевых народов в цивилизации Центральной Азии» УБ., 1974, с. 63.

43. Цадигууд монголын уран зохиол ба нийт урлагт үлэмжхэн нөлөөлсөн юм. Эрдэнэ зуу хийдийн ханан дээр энэтхэг Ловон Бавогийн зохиосон 34 цадигийн зураг одоо ч хүртэл бий. -«Монголын уран зохиолын тойм» боть 11, УБ., 1977, 393-р тал.

44. Дж. Неру Взгляд на Всемирную историю. М., 1975, Т. I, с. 234

45. «Кэсэнэ хааны тууж» буюу «32 модон хүний үлгэр» нь Бигармижид хааны намтрын гуравдахь ном бөгөөд түүнийг XVII зууны үед Өндөр гэгээний шадар «Чулуун хуруут» азар энэтхэг хэлнээс орчуулжээ.

Ц.Дамдинсүрэн. «Монголын уран зохиол судлалын зарим асуудал. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал» 3-р дэвтэр. 54-р тал; -Монголын уран зохиолын тойм II, УБ., 1977, 347—348, 350-р тал

Эдгээр үлгэр туульс болон үргэлжилсэн үгийн зохиолууд нь сэдвийн хувьд харилцан адилгүй боловч монгол-энэтхэгийн соёлын хэлхээ холбоог эрт дээр үеэс нааш гүн зузаан байсныг илтгэн харуулах бөгөөд Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн академич Б. Я. Владимирцовын хэлснээр «...нүүдэлчин монгол ард түмэн харь холын Энэтхэгтэй соёлын хувьд олон зүйлийн нягт холбоотой болсны»<sup>46</sup> гэрч юм.

Монголын ард түмэн Манж чин улсын ноёрхолд, Энэтхэг нь Английн эрхшээлд байсан 200 гаруй жилийн турш монгол-энэтхэгийн соёлын уламжлалт шууд харилцаа тасалджээ. Гагцхүү 1921 онд Монгол, 1941 онд Энэтхэг тус тус тусгаар тогтнолоо байлдан олсноос хойш тэдгээрийн хоорондох харилцаа цоо шинэ зарчмын үндсэн дээр дахин сэргэсэн билээ. БНМАУ-д ардын засгийн жилүүдэд соёлын хувьсгал хийж хуучин нийгмээс өвлөн авсан соёлын байгуулалтыг шинэчлэн шашин төрийг тусгаарлан, ардыг гэгээрүүлэх зэрэг ардчилсан өөрчлөлтүүдийг амжилттай явуулж дотооддоо дарлах дарлагдах ёсгүй шинэ нийгмийг цогцлон байгуулж, гадаадаа улс түмний хооронд энх тайван, найрамдал, хөгжил давшлийн бодлогыг тууштай явуулж ирлээ.

Бүгд Найрамдах Энэтхэг улс нь БНМАУ-ыг 1955 онд буюу манай улсыг НҮБ-д гишүүнээр элсэн орохоос даруй 6 жилийн өмнө хүлээн зөвшөөрсөн билээ. Энэтхэгийн ард түмэн Монголын тусгаар тогтнолыг тууштай дэмждэг юм. 1960 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 15-р чуулган дээр бандид Жавхарлал Неру манай улсыг НҮБ-д элсүүлэх талаар чухал мэдэгдэл хийсэн бөгөөд 16-р чуулган (1961 он) дээр Монголыг тэрхүү олон улсын байгууллагад байраа эзэлсэн явдалд Энэтхэг улс тааламжтай байгаагаа илэрхийлж манай төлөөлөгчдөд халуун баяр хүргэж байжээ.

Дипломат харилцаа тогтоож элчин сайдуудаа солилцсоны дараа 1957 оны 12-р сард Дели хотноо Энэтхэгийн Парламентын гишүүн Шийл Бадра Яжий, Махаврат Видиаланкар нар дарга, орлогчтай Энэтхэг-Монголын соёлын нийгэмлэг байгуулагдаж ийм нийгэмлэгүүд удалгүй Энэтхэгийн бусад хотуудад байгуулагджээ. Мөн үеэр ардын зураач Н. Чүлтэм даргатай Монгол-Энэтхэгийн соёлын нийгэмлэг байгуулагджээ.

Үүний дараах нэг чухал үйл явдал бол тус хоёр орны хооронд 1961 оны 3-р сарын 9-нд Дели хотноо онц бүрэн эрхт элчин сайд Мангалын Дүгэрсүрэн (одоо БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд) Энэтхэгийн тэр үеийн эрдэм шинжилгээ-соёлын яамны сайд проф. Хумаюн Кабир нар гарын үсэг зурсан Монгол-энэтхэгийн соёлын хэлэлцээр болно. Уг хэлэлцээрийн 1-р зүйлд хэлэлцээр байгуулагч талууд нь соёл, шинжлэх ухаан, гэгээрэл, утга зохиол, урлагийн салбарт хамтран ажиллах эрмэлзлэлээ илэрхийлжээ. Хэлэлцээрийн 2-р зүйлд заахдаа хэлэлцээр байгуулагч талууд нь соёл, урлагийн үзэсгэлэн, профессор, эрдэмтэд, гэгээрлийн ажилтан, оюутан харилцан солилцох замаар тус орнуудын хооронд соёл, шинжлэх ухаан, урлаг, боловсрол, эрүүлийг хамгаалах, спортын зэрэг байгууллагуудын нягт хамтын ажиллагааг хөгжүүлэхийг бүхий л талаар дэмжинэ» гэжээ.

Энэ хэлэлцээрийн үндсэн дээр манай орнуудын соёлын хамтын ажиллагаа соёлоор харилцах хоёр талын программын дагуу биелэгдэж байна. Эдгээр программын ачаар Монгол, Энэтхэгийн хооронд урлагийн хэсгүүд, эрдэмтэд, оюутан солилцсон бөгөөд тэдгээрийн тоо жил бүр өсч байна.

Манай улсын нэрт эрдэмтэд, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Б.Ширэндэв, дэд ерөнхийлөгч Ш. Бира, академич Ш. Нацагдорж (түүхч), Ш. Лувсанвандан (хэл бичиг), Ц. Дамдинсүрэн (хэл бичиг, зохиолч), Б. Ринчен (хэл шинжлэлч, зохиолч), Ч. Жүгдэр (философич) гэх мэт олон хүн Энэтхэгт зочилж Энэтхэгийн соёлын талаар олон арван өгүүлэл, ном зохиол бичжээ.

Энэ завсар Монгол нь Энэтхэгийн олон тооны хүндэт зочид, эрдэмтдийг хүлээн авчээ. Энэтхэгийн дэд ерөнхийлөгч агсан д-р С. Радхакриш нан Монголд 1957 онд зочилж Улаанбаатар хот дахь Монгол улсын их сургуулийн хүндэт доктор цолоор шагнагджээ. Тэрээр БНМАУ-ын ШУА-ийн гадаад гишүүн байв. Д-р Рагу Вира (1902—1963) Энэтхэгийн соёлын олон улсын институтдээ 1960-аад оны эхээр Монголын судлалын тасаг нээжээ.

Монгол Ганжурын 108 ботийг хэвлэх ажлыг проф. д-р Рагу Вира-г 1963 онд нас барсны дараа хүү д-р Локеш Чандра эхэлж 10 гаруй жилийн дотор 40 шахам ботийг хэвлэсний бүрэн хувийг манай улсын номын сан хүлээн авсаар байна. Ийнхүү манай хоёр ард түмний соёлын өв уламжлалтай холбогдсон бичиг дурсгал, эх бичмэл зэргийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох нь монгол, Энэтхэгийн хоорондох соёлын хамтын ажиллагааны нэг хэлбэр болж байгаа юм.

Жавхарлал Неругийн Их сургуулийн олон улсын судлалын институт (сургууль)-ын Төв Азийн судлалын хэлтэс нь судлалын программаа өргөтгөж Гималайн дагуух хилийн район, Хятад, Монголын түүх судлалыг хамрах болжээ. Орчин үеийн Энэтхэг нь Монголын түүхээр проф. Мухамед Хабиб, проф. С. А. Рашид (хоёулаа Алигархын лалын их сургууль) нарын зэрэг нэрт хүмүүсийг төрүүлжээ..

Монголд Төвд, Энэтхэгийг оролцуулсан дорнодахины судлалын асуудлыг хэд хэдэн хүрээлэн эрхэлж байна. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нь бичгийн дурсгалыг судлах, хэвлэн нийтлэх ажлыг гүйцэтгэж байна Энэ хүрээлэнгийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнууд монголын соёлын өвийн түүх, түүний Энэтхэгийн соёлтой уламжлалт хэлхээ холбоотойн талаар олон тооны өгүүлэл, нэгэн сэдэвт зохиол бичиж туурвижээ. Энэ хүрээлэнгээс бэлтгэн 1977 онд хэвлэсэн XVII—XVIII зууны үеийн «Монголын уран зохиолын тойм» (боть 1) нь энэтхэгийн уран зохиолтой холбогдол бүхий зохиолуудаар 120 гаруй хуудас хамгийн том бүлэг багтаасан шинэ бүтээл юм.

Сүүлийн үеийн бусад бүтээлээс Ц. Дамдинсүрэнгийн «Рамаяна Монголд дэлгэрсэн нь» (1976), Б. Ринчен, Калидасын «Үүлэн зардас»-ийн төвд, нангиад, англи гурван хэлнээс монгол болгосон 4 монгол хувилбарын эмхтгэл (1963), Д. Нямсүрэнгийн хинд хэлнээс хөрвүүлсэн «Рамаяна»-ын хураангуй хувилбар (1969), Г. Гэндэндармаа хинд хэлнээс хөрвүүлсэн Висну Шармагийн «Панчатантра»-гийн орчуулга (1972) зэрэг бүтээлийг дурдаж болно. Эдгээрээс гадна эрдэм шинжилгээний бусад цувралууд, орчуулгын зохиолуудын зэрэгцээгээр Рабиндранат Тагорын «Гитанжа ли» (өргөлийн дуулал) ба «Гора», түүнчлэн Мулк Раж Ананд, Кишан Чандр, Кважа Ахмад Аббас нарын зэрэг энэтхэгийн орчин үеийн зохиолч, яруу найрагчдын бүтээлээс орчуулж олон мянган хувиар хэвлэжээ.

1976 онд хуралдсан МАХН-ын XVI их хурал, Монгол-Энэтхэгийн харилцаа нь тус хоёр орны харилцааны үндсэн зарчмыг баталсан 1973 оны Монгол—Энэтхэгийн хамтарсан тунхаглалын үзэл санааны дагуу цаашид хөгжинө гэдэгт итгэж байгаагаар илэрхийлсэн билээ.

МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын 1973 онд

Энэтхэгт хийсэн айлчлалтын дүнд гарын үсэг зурсан энэхүү хамтарсан тунхаглал бол манай хоёр орны соёлын харилцааны үзэл санаа болон зарчмыг тодорхойлоод зогсоогүй бүхий л Ази тивийн энх тайван, аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс Монгол-Энэтхэгийн харилцааг цаашид хөгжүүлэх хууль зүйн үндсийг тавьсан юм. Монгол-Энэтхэгийн соёлын харилцааны хөгжилтөд манай Гадаад Явдлын яамны сайд Энэтхэгт айлчлах үеэр 1978 оны 2-р сард байгуулсан соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хэлэлцээр шинэ хуудас нээлээ. Ази тивийн энх тайван, аюулгүй байдал, өнөө үеийн улс төрийн намжмал байдлын цаашдын өрнөлт нь соёлын талаархи олон улсын хамтын ажиллагаанд улам өргөн бололцоо олгоно.

Монгол, Энэтхэг хоёр нь соёлын талаар олон улсын байгууллагын хүрээнд ч хамтран ажиллаж байна. 1966 онд ЮНЕСКО-гийн 14-р ерөнхий бага хурлаас «Төв Азийн ард түмний соёл иргэншлийг судлах» томоохон программыг баталсан билээ. Энэ программ дорхи үндсэн зүйлийг багтаасан нь:

1. Кушааны үеийн Төв Азийн түүх, археологи
2. Төмөрийнхний үеийн Төв Азийн урлаг.
3. Төв Азийн ард түмнээс шинжлэх ухааны хөгжилтөд оруулсан хувь нэмэр (9-13-р зуун).
4. Төв Азийн ард түмний утга зохиол.
5. Төв Ази дахь үзэл санаа, философи сэтгэлгээний түүх<sup>47</sup> зэрэг болно.

Монгол, Энэтхэг хоёулаа энэ программд нэгдэн орж (Монгол 1970 оноос) Энэтхэг нь ЮНЕСКО-той хамтран ажиллах Энэтхэгийн үндэсний комиссын дэргэд Төв Азийн судлалын үндэсний зөвлөх хороог байгуулжээ. БНМАУ-ын ШУА, Төв Азийн иргэншил судлах Монголын үндэсний комиссоос эрхлэн 1974 онд «Төв Азийн иргэншилд нүүдэлчдийн роль» олон улсын симпозиум зохион байгуулжээ. Симпозиумд оролцсон Энэтхэгийн төлөөлөгч д-р Рахул хэлэхдээ энэ симпозиум нь Төв Азийн орнуудын хоорондох бүсийн хамтын ажиллагааны түүхэнд тэмдэглэлт үйл явдал боллоо» гэжээ. Уг программд манай эрдэмтэд идэвхтэй оролцож байгаа бөгөөд цаашдаа Төв Азийн ард түмний түүхийг судлагчид болон Энэтхэг, Афганистан, Ираны эрдэмтэдтэй нягт холбоотой ажиллахыг чухалд үздэг юм.<sup>48</sup>

Олон улсын чанартай хамтын ажиллагааны зэрэгцээгээр хоёр орны хоорондох соёлоор харилцах программ нь соёл урлаг, археологи, музей, радио, телевиз болон спортын талаар төлөвлөгчид харилцан солилцох, хамтран ажиллах өөр нэгэн шугам болно. Тийм программ ёсоор зохиолчид, эрдэмтэд, урлагийн групп, спортын баг, үзэсгэлэн зэргийг солилцдог. Эдгээр программыг биелүүлэх явцын дунд тус хоёр орон нь нэг нэгийнхээ соёлыг хүндэтгэн харилцан бие биеэсээ суралцдаг юм. Чухам ийм хэрэг үйлсэл, олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйтэтгэдэг бөгөөд түүхэн үүднээс авч үзвэл тус хоёр орон эрт дээр үеэс соёлоор холбогдож ирсэн явдал өнөө үед манай орнуудын хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх нэг шижим болно.

47. Б. Г. Гафуров, А. И. Мирошников. «Изучение цивилизации Центральной Азии» М., 1976, с. 38.

48. Ширендыб. Некоторые вопросы исследования проблем-«Роль кочевых на родов в цивилизации Центральной Азии» в кн. «Роль кочевых, народов в цивилизации Центральной Азии» УБ., 1974, с. 3.

МОНГОЛО-ИНДИЙСКИЕ КУЛЬТУРНЫЕ СВЯЗИ  
В ПРОШЛОМ И НАСТОЯЩЕМ  
РЕЗЮМЕ

В нашей исследовательской литературе начало культурных отношений Монголии с Индией обычно связывается с периодом распространения буддизма в Монголии (примерно V—V вв. н. э.) и если не совсем, то мало учитываются те сотни столетий, которые прошли с момента первоначального проникновения буддизма до его принятия как государственную религию в ужани IV—V вв. Однако, за этот период буддизм в Монголии больше всего переплетался с элементами светской или гражданской культуры Индии, в частности, слитературой, искусством, философией и медициной. Поэтому по мнению автора, больше внимания должно быть уделено именно раннему периоду распространения буддизма через страны Центральной Азии и Восточный Туркестан среди гуннов (III в. до н. э. 1 в н. э.)

Автор затрагивает вопрос о культурных связях между Монголией и Индией в добуддийский период, и приводя археологические, антропологические и языковые данные, он предполагает, что древние кочевники Центральной Азии, включая протомонголов и монголоидные народности, могли внести свой вклад в формирование древнеиндийской цивилизации в долине Инда.

Ссылаясь на выводы монгольских ученых, в частности академика Ш. Бира, и поддерживая их мнения, автор считает, что приобщение монголов к индо-тибетскому культурному миру явилось сильным нейтрализующим фактором на пути проникновения китайского влияния в духовную сферу жизни монгольского общества.<sup>1</sup> Автор приводит некоторые конкретные примеры, подтверждающие влияние политической и философской концепции древней Индии на духовную жизнь монголов («теория» происхождения монгольских хаганов от древнеиндийских царей, концепция «двух принципов»).

В статье уделяется особое внимание литературным связям Монголии с Индией оценкам и состоянию этих связей, включая вопрос об «адаптации» индийского народного творчества и его синтезе с местным творчеством. Автор также анализирует переводную литературу (Ганджур и Данджур) на монгольском языке. Культурные связи между Монголией и Индией были прерваны на более чем 200 лет, когда обе страны находились под влиянием иностранных колонизаторов. Только благодаря завоеванию своей независимости, Монголия и Индия возобновили свои культурные связи на основе совершенно новых принципов, отвечающих интересам народов двух стран в духе укрепления мира, сотрудничества и взаимопонимания. Новый период в развитии монголоиндийских культурных отношений начался с установлением между ними в 1955 г. дипломатических отношений, основанных на принципах равноправия и взаимного уважения суверенитета обеих стран. В 1961 году было подписано культурное соглашение между Монголией и Индией, которое значительно расширило культурные связи между двумя странами. Большое значение имеет

1. Ш. Бира. Монголия и страны Центральной Азии. (К изучению истории и культурных связей Монголии со странами Центральной Азии) «БНМАУ-ын шинжлэх ухааны Академийн мэдээ», № 4., 1976, с. 35.)

монголо-индийская декларация 1913 г, провозглашенная в итоге визита Первого секретаря ЦК МНРП, Председателя Президиума Великого Нароного Хурала МНР Ю. Цеденбала в Индию. Она не только положила юридическую основу развития монголо-индийских отношений в дальнейшем но и служит примером успешного сотрудничества между странами с различным социальным строем. В свете этой декларации культурные связи между нашими странами получили свое дальнейшее развитие.

XVII съезд МНР выразил уверенность в том, что монголо-индийские отношения будут развиваться в духе совместной монголо-индийской декларации 1913 года.

Новым рубежом в развитии монголо-индийских культурных связей также явилось подписанное в 1918 году в Дели монголо-индийское соглашение по сотрудничеству в области культуры и науки. За последнее время сотрудничество между нашими странами в области науки и культуры получило значительный размах и по линии международных организаций таких, как ЮНЕСКО. МНР и Индия плодотворно сотрудничают в целях реализации международного проекта ЮНЕСКО по изучению цивилизаций Центральной Азии.